

05.2.Номын сангийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

Үүсэж болзошгүй эрсдэлийн тодорхойлолт: Номын сангийн үйл ажиллагааны чанар, аюулгүй байдал, хүртээмж алдагдах

Үнэлгээ хийх объект: Номын сан, их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн номын сан, соёлын төв, соёлын ордон

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Түүх, соёлын дурсгалын үнэ цэнэ		
1.1	Хосгүй үнэт гар бичмэл, барын ном, ганц хувьтай ном судар, дурсгал хадгалдаг	10
1.2	Үнэт дурсгал хадгалдаг	5
1.3	Бусад	1
Хоёр. Сан хөмрөгийн бүрдүүлэлт		
2.1	Сан хөмрөгийн баяжуулалт хийгээгүй	10
2.2	Сан хөмрөгийг улсын төсвөөр баяжуулсан	5
2.3	Сан хөмрөгийг заавал авах хувь, худалдан авах, нөхөн бүрдүүлэх, ном солилцох, улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар тогтмол баяжуулдаг	1
Гурав. Номын сангийн хамгаалалт, хяналт		
3.1	Дохиолол, хамгаалалтын системгүй, системтэй боловч ажилладаггүй	10
3.2	Дохиолол, хамгаалалтын системтэй боловч бүрэн ажилладаггүй	5
3.2	Дохиолол, хамгаалалтын систем бүрэн ажилладаг	1
Дөрөв. Аюулгүй байдал, сэргээн засварлалт		
4.1	Ном судрыг алдсан, үрэгдүүлсэн, гэмтээсэн, устгасан, гэмтсэн, тохиолдол гарсан, номын ариутгалыг хийдэггүй, шаардлагатай ном, хэвлэлийг сэргээн засварлаагүй	10
4.2	Алдагдсан буюу гэмтээгдсэн ном, хэвлэлийг төлүүлсэн, номын ариутгалыг хийдэггүй, шаардлагатай ном, хэвлэлийг сэргээн бүрэн засварлаагүй	5
4.3	Ном, судар алдсан, үрэгдүүлсэн тохиолдол гараагүй, номын ариутгалыг тогтмол хийдэг, шаардлагатай ном, хэвлэлийг сэргээн засварладаг	1
Тав. Сан хөмрөгийн хадгалалтын горим		
5.1	Сан хөмрөг, үзүүллэгийн өрөө нь агаарын чийг тохируулагч, дулаан, гэрэлтүүлэгч хэмжигч багаж, шавж устгагч, мөөгжих, тоосжих, чийгшихээс хамгаалах тоног төхөөрөмжөөр хангагдаагүй	10
5.2	Сан хөмрөгийн өрөө нь агаарын чийг тохируулагч, дулаан хэмжигч, шавж устгагч, мөөгжих, тоосжих, чийгшихээс хамгаалах тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй	5
5.3	Сан хөмрөг, үзүүллэгийн өрөө нь агаарын чийг тохируулагч, дулаан, гэрэлтүүлэгч хэмжигч багаж, шавж устгагч, мөөгжих, тоосжих, чийгшихээс хамгаалах тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан	1

Зургаа. Номын сангийн үйлчилгээний цахимжуулалт		
6.1	Номын сангийн программ ашигладаггүй, бар код уншигч, соронзон хаалга зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдаагүй	10
6.2	Номын сангийн программ ашигладаг боловч лиценз эрх нь дууссан, бар код уншигч, соронзон хаалга зэрэг тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй	5
6.3	Номын сангийн программ ашигладаг, бар код уншигч, соронзон хаалга зэрэг тоног төхөөрөмжийг ашигладаг	1
Долоо. Уншлагын танхим		
7.1	Уншлагын танхим нь байгалийн ба хиймэл гэрэлтүүлэггүй, стандартад нийцсэн дулаан, чийгшил, орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлдэггүй	10
7.2	Уншлагын танхим нь байгалийн ба хиймэл гэрэлтүүлэг хослоогүй, стандартад нийцсэн дулаан, чийгшил, орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид бүрэн үзүүлдэг	5
7.3	Уншлагын танхим нь байгалийн ба хиймэл гэрэлтүүлэг хосолсон, стандартад нийцсэн дулаан, чийгшил, орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлдэг	1
Найм. Барилга, байгууламж		
8.1	Барилга, байгууламж нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, зориулалтын бус, ашиглалтын болон стандартын шаардлага хангахгүй, сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдээгүй	10
8.2	Барилга, байгууламж нь батлагдсан зураг төслийн дагуу баригдсан боловч их засвар хийх шаардлагатай, зарим сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдээгүй	5
8.3	Барилга, байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын, стандартын шаардлага хангасан, сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдсэн	1
Ес. Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
9.1	60 хүртэл хувь нь мэргэжлийн ажилтантай	10
9.2	61-99 хүртэлх хувь нь мэргэжлийн ажилтантай	5
9.3	Мэргэжлийн ажилтнаар бүрэн хангагдсан	1
Арав. Бүтээлч үйлдвэрлэл		
10.1	Соёл, олон нийтийн ажил, арга хэмжээ зохион байгуулдаггүй	10
10.2	Тухайн жилд бүтээлч байдалд тулгуурлан, үнэ цэнийг нэмэгдүүлж бий болгосон соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн, нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ном хэвлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг 4 хүртэл зохион байгуулсан	5
10.3	Тухайн жилд уншлагыг дэмжих олон талт арга хэмжээ, тэргүүний уншигч-иргэн, гэр бүл, байгууллагыг алдаршуулан сурталчлах соёл, олон нийтийн ажил, арга хэмжээг 4-өөс дээш зохион байгуулсан	1
Арван нэг. Соёлын боловсрол		
11.1	Соёлын боловсрол олгох хөтөлбөргүй, үйл ажиллагаа тогтмолжоогүй	10
11.2	Соёлын боловсрол олгох 4 хүртэл хөтөлбөрийг боловсруулж, үйл ажиллагаа тогтмолжсон	5
11.3	Соёлын боловсрол олгох 4-өөс дээш хөтөлбөр боловсруулж, үйл ажиллагаа тогтмолжсон	1
Арван хоёр. Үйлчилгээний соёл		

12.1	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд 2 буюу түүнээс дээш гомдол гарч байсан	10
12.2	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд гомдол гарч байсан	5
12.3	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар гомдол гарч байгаагүй, үйлчилгээний ажилтнууд соёл, ёс зүйн сургалтад хамрагдаж мэргэшсэн	1
Арван гурав. Соёлын төсөв бүрдүүлэлт		
13.1	Төсвийн жилд өр, авлага үүссэн, төсвийн сахилга бат хангалтгүй	10
13.2	Тухайн жилийн батлагдсан төсвийн багцын дүнд багтаан үйл ажиллагаа эрхэлсэн	5
13.3	Тухайн жилийн батлагдсан төсвийн багцын дүнг 50 хувиас дээш нэмэгдүүлсэн, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг	1
Арван дөрөв. Дотоодын хяналтын тогтолцоо		
14.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтангүй	10
14.2	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай боловч үйл ажиллагаа хэвшээгүй	5
14.3	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай, үйл ажиллагаа хэвшсэн	1
Арван тав. Өмнөх хяналт шалгалтын түүх		
15.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
15.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
15.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

75-150 оноо авсан бол их эрсдэлтэй

45-74 оноо авсан бол дунд эрсдэлтэй

44 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй